

ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖ ТҮҮНИЙ ЗОРИУЛАЛТ, АЧ ХОЛБОГДОЛ

*У.Загдзэсэм**

Япон улс нь дэлхийн өндөр хөгжилтэй гүрний нэг бөгөөд эдүгээ НҮБ-д оруулж буй хөрөнгийн хэмжээгээрээ /Нийт хөрөнгийн 20%-ийг оруулдаг./ АНУ-ын дараа хоёрдугаарт орж, хөгжиж буй орнуудад үзүүлж буй тусламжийн хэмжээгээрээ 1989 оноос хойш дэлхийд тэргүүлж байна.

Японы гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны нэг хэлбэр нь ODA буюу засгийн газрын хөгжлийн тусламж юм. "ODA" гэдэг нь "Official development assistance" гэсэн англи үгийн товчилсон утга юм. Энэхүү засгийн газрын хөгжлийн тусламж нь өнөөдөр дэлхийн шинэ тулгар хөгжиж байгаа олон орныг хамарч тэдгээр орнуудын хөгжлийн явц дахь тулгамдсан хүнд хэцүү асуудлуудыг шийдэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Японы Засгийн газар 1992 онд өөрийн тусламжийн бодлогын дөрвөн зарчмыг тодорхойлсон юм. Үүнд :

1. Байгаль орчныг хамгаалах, ба хөгжлийг дэмжих нь гол шугам байх болов.
2. Тусламжийг цэргийн зорилгод мөн, олон улсын мөргөлдөөнийг даамжруулахад ашиглахгүй байх
3. Хүлээн авагч орон тусламжийг цэргийн зардлаа нэмэгдүүлэх үй олноор устгах зэвсэг үйлдвэрлэх, зэвсэг экспортлох буюу импортлоход бус, олон улсын энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэх, өөрийн нөөц бололцоогоо эдийн засаг, нийгмийн хөгжилдөө чиглүүлэхэд бүрэн анхаарна.
4. Ардчиллыг дэмжих, зах зээлийн эдийн засагт шилжих, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахад чиглүүлэхэд оршино¹ хэмээн заажээ.

ODA-ийн тусламж нь урьд өмнө нийгэм -эдийн засгийн дэд бүтцийн байгууламж, хүмүүсийг сургахад ихэнхдээ зориулагдаж байсан бол одоо орчныг хамгаалах, хүн амын хэт өсөлтийг

* У.Загдзэсэм - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

хязгаарлах, ДОХ зэрэг өвчинтэй тэмцэх мэтийн том асуудлуудыг хамрах болов. Мөн ардчиллыг өрнүүлэх, зах зээлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг дэмжих гэх мэт шинэ чиглэлүүдэд зориулагдах болов.

1999 оны байдлаар Япон улсын Засгийн газар нийт 10 тэрбум 497 сая долларын Хөгжлийн албан ёсны тусламжийг хөгжиж буй орнуудад үзүүлснээс 6 тэрбум 630 сая гаруй долларыг Азийн орнуудад, 994 сая 630 мянган долларыг Африкийн орнуудад, 814 сая 410 мянган долларыг Латин Америкийн орнуудад олгожээ².

Японы Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжийг олгох гол нөхцөл нь улс орны хөгжлийн түвшинг илэрхийлдэг үндсэн үзүүдэлт болох нэг хүн амд ноогдох үндэсний орлого юмуу үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээ байдаг.

Засгийн газрын хөгжлийн тусламж буюу ОДА-гийн тусламжийг үндсэнд нь хөрөнгө мөнгөний хэлбэрээр, техникийн хамтын ажиллагааны хэлбэрээр гэж хоёр хувааж үздэг. Үүнд хөрөнгө мөнгөний тусламж дийлэнх хувийг эзэлдэг. Хөрөнгө мөнгөний тусламжийг дотор нь буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл гэж хоёр хуваадаг. Хөнгөлөлттэй зээлийг ихэвчлэн японы мөнгөн тэмдэгт иенээр тооцдог учраас олон улсын практикт иенийн зээллэг гэж ч нэрлэгддэг. Японы засгийн газрын буцалтгүй тусламж нь 1996 онд бараг 5,4 тэрбум ам. долларт хүрсэн бөгөөд түүний 3,2 тэрбум ам. доллар нь буцалтгүй мөнгөн тусламж, 2,2 тэрбум ам. доллар нь техникийн тусламж байжээ. Засгийн газрын бага хүүтэй, урт хугацаатай буюу хөнгөлөлттэй иений зээл нь 1996 онд 2 тэрбум 769 сая ам. долларт хүрчээ³.

Буцалтгүй тусламж иений зээллэг аль алинийг нь болзолтой, болзолгүй гэж хоёр ангилдаг. Болзолтой тусламж, зээллэгийг авсан орон тэрхүү хөрөнгө мөнгийг Японы пүүс, үйлдвэрийн газраас тоног төхөөрөмж бусад зүйлийг худалдан авах замаар зөвхөн Японд зарцуулдаг бол болзолгүй тусламжаар авсан хөрөнгө мөнгийг зөвхөн Японд биш, бусад оронд зарцуулж ашиглах эрхтэй байдаг байна. Японы нийт хөгжлийн тусламжинд болзолгүй тусламжийн хэмжээ давамгайлдаг ажээ.

Япон улсын засгийн газар хөгжлийн тусламж авч буй орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинг харгалзан ялгаатай бодлогыг хэрэгжүүлдэг ажээ. Тухайлбал, туйлын ядуу орон нь зээлийг эргүүлж төлж чадахгүй учир тэдэнд буцалтгүй

тусламж, мөн техникийн хамтын ажиллагаагаар тусалдаг. Нэлээд хөгжсөн оронд зээл болон техникийн хамтын ажиллагаагаар, түүнээс дээгүүр оронд зөвхөн зээл, өндөр хөгжилд хүрч буй оронд зөвхөн техникийн хамтын ажиллагаагаар тусалдаг. Жишээ болгоход, Япон улс Тайландад зээл болон техникийн хамтын ажиллагаагаар, Малайз, Бразил, Мексикт техникийн хамтын ажиллагаагаар тусалж Сингапур, БНСУ нь өөрсдөө хандивлагч болон хувирч буйг харгалзан тэдэнд технологийг шилжүүлэх хөтөлбөрөөр тусламж үзүүлдэг.

Буцалтгүй тусламжийг дотоод бүтцийнх нь хувьд ерөнхийд нь 6 төрөл зүйлд ангилдаг. Үүнд: ерөнхий тусламж, усны хангалт, соёлын тусламж, осол гамшгийн үед үзүүлэх онцгой тусламж хэмээн ангилдаг. Үүнээс ерөнхий буцалтгүй тусламжийг хөдөө аж ахуй, хүн эмнэлэг зэрэг хүн амын үндсэн хэрэгцээг хангах салбарт, мөн боловсрол, эрдэм шинжилгээ, боловсон хүчин сургаж бэлтгэх үйлсэд зориулж олгодог. Түүнчлэн энэ ангилалд буурай хөгжилтэй орнуудын өр төлбөрийн дарамтыг хөнгөвчлөх зорилготой тусламжийг оруулдаг. Ер нь хүн ардын амьжиргаа, нийгмийн дэд бүтцийн салбаруудад буцалтгүй тусламж олгодог гол зарчимтай байдаг байна.

Техникийн хамтын ажиллагааг буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд хөгжиж буй орны мэргэжилтэнг хүлээн авч мэргэжлийг нь дээшлүүлэх, Японоос мэргэжилтэн илгээж ажиллуулах, зураг төсөл боловсруулж өгөх, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх гол зорилготой байдаг ажээ.

Японы засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг гол төлөв хөгжиж буй орнуудад цахилгаан станц, зам гүүр, усан боомт, нисэх онгоцны буудал зэрэг эдийн засгийн дэд бүтцийн барилга объектыг өргөтгөх, барьж байгуулахад зориулан олгож ирсэн байна. Түүнчлэн засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг сүүлийн үед хөтөлбөр төслийн чанартай тусламж үзүүлэхэд олгох хандлага бас ажиглагдах болжээ. Тухайлбал, тусгай барилга байгууламж барьснаар бүхэлдээ шийдэгдэх боломжгүй хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, аж үйлдвэрийн бүтцийг өөрчлөх зэрэг цогцолбор бодлого, хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээнд Японы засгийн газрын хөнгөлөлттэй иенийн зээлийн хэлбэр нь туйлын чухал, үр ашигтай хэлбэр юм. Мөн улсын төсвийн алдагдалтай, гадаад валютын нөөц хомс улс оронд

үйлдвэрийн тоног төхөөрөмж , хөдөө аж ахуйн машин механизм импортлоход зориулсан таваарын зээл нэртэй мөнгөн зээл олгох явдал ч ахицтай болж байгаа ажээ. 1997 онд Япон улсын засгийн газраас үзүүлсэн иенийн зээллэгийг авч үзвэл Индонез 3747тэрбум иен, Хятад 254 тэрбум иен, Энэтхэг 1914 тэрбум иен дараа нь Тайланд, Филиппин, Пакистан, Малайз, Хойд Солонгос, Бангладеш, Шриланк улсууд иенийн зээл авсан хэмжээгээрээ эхний аравт оржээ.⁴

Тус улсад буцалтгүй тусламжийн асуудлыг Гадаад Хэргийн яамны харьяа Олон улсын хамтын ажиллагааны агентлаг буюу “JICA” хэмээх байгууллага хариуцдаг бөгөөд иенийн буюу засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн асуудлыг Японы Гадаад Хэргийн яам , Сангийн яам, Худалдаа үйлдвэрийн яам, Эдийн засгийн төлөвлөлтийн газар дөрвүүл хамтран шийдвэрлэдэг, аль нэг нь татгалзвал тухайн асуудал шийдэгдэхгүй болдог журамтай ажээ.

Японы хөгжлийн тусламжийг дэлхийн бүс нутгийн чиглэлээр авч үзбэл Ази, Африк, Латин Америк болон Ойрхи Дорнодын улс орнуудад голлон үзүүлсээр ирсэн нь дээр өгүүлсэн баримтаас тодорхой байна. Ази тивийн улсууд дотроос Зүүн өмнөд азийн орнууд энэхүү тусламжийг хамгийн ихээр авч ирсэн бөгөөд Японы эдийн засгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудал эрхэлдэг Гадаад Хэргийн яам, Сангийн яамнаас жил бүр хэвлэн гаргадаг “Манай улсын засгийн газрын хөгжлийн тусламж – ODA цагаан ном” /“Вага күни-но сэйфү кайхацү энжэ”/ 2001 оны дугаарт авч буй тусламжийн хэмжээгээрээ Хятад нэгдүгээрт, дараа нь Индонез, Энэтхэг, Тайланд, Филлипин, Вьетнам, Иордан, Шриланк, Бангладеш, Египет гэсэн орнууд эхний аравт оржээ.⁵ Дашрамд дурдахад, Хятад улс жилдээ 1 тэрбум доллар, Вьетнам улс 500 сая долларын хөгжлийн тусламжийг ашиглаж байна.⁶

Япон улс Засгийн газрын тусламж үзүүлэх гэж буй тухайн орны цэргийн зардал, төсөв, зэвсгийн экспорт, импортын нэмэгдэж буй байдал, цөмийн болон бактериологи, химийн зэрэг их хэмжээний хөнөөх зэвсгийг оруулан туршиж буй, мөн эзэмшиж буй байдал, ардчиллын үйл явц гэх мэтийг харгалзан тусламжийн хэмжээгээ хорогдуулах, түр зогсоох зэрэг арга хэмжээг авдаг аж. Тухайлбал. 1998 онд Энэтхэг, Пакистан хоёр улс цөмийн туршилт хийснээс болж Японы засгийн газар уг хоёр улсад олгож байсан тусламжаа түр зогсоож байлаа.

Дэлхийн улс орнуудад үзүүлж буй Японы Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламж нь Японы ард түмний татварын хөрөнгөөс бүрддэг учраас Засгийн газар нь энэ тусламжийн талаар ард түмнийхээ дунд санал асуулга явуулж, ард түмнийхээ санаа боллыг судлан үр дүнг нь ил тод нийтлэн тусламж хэрэгжүүлэх бодлогодоо тусгалаг байна. 1998 онд явуулсан санал асуулгын 12 дахь асуулт нь “Японы ОДА –г гол ямар салбарт хэрэглэхийг зөв гэж үздэг вэ? Тэдгээрийг нэрлэнэ үү?” гэсэн асуулт байжээ. Энэ асуултын хамгийн өндөр хувийг 50 шахам хувийн саналаар эрүүл мэнд, ядуурлыг бууруулах салбар авчээ. Дараа нь нийгмийн хамгаалал, боловсрол, хүнсний тусламж 30 хувь, гамшгийн эсрэг яаралтай тусламж, байгаль хамгаалах /ой хамгаалал/ салбарт 25 хувийн санал өгсөн байна.⁷

Манай улс Японы Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламжийг 1990 оноос эхлэн авч, шилжилтийн үеийн эдийн засгийн хямрал бэрхшээлийг даван туулахад зориулан ашиглаж ирлээ. Үүнд тусламжийн гол нь манай улсын эдийн засгийн хөгжлийн үндсэн суурь болох дэд бүтэц, хүний хөгжил, хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуй, хүний амьдралын наад захын хэрэгцээ зэрэг улс орны амьдралын бүх салбарт өргөн ашиглагдаж байна. Тоогоор илэрхийлбэл 2002 он хүртэлх хугацаанд нийт 35,6 тэрбум иений хөнгөлөлттэй зээл, 55,6 тэрбум иений буцалтгүй тусламж, 18,8 тэрбум иений техникийн хамтын ажиллагааны тусламжийг⁸ үзүүлсэн нь Монгол Улсад хандивлагч орнуудаас үзүүлж буй тусламжийн дотор хэмжээгээрээ хамгийн их бараг 40-өөд хувийг нь эзэлж байна. Японы Засгийн газрын хөгжлийн тусламжийг одоогоор дэлхийн 160 гаруй улс авч ажиллаж буйн дотроос Монгол улс буцалтгүй тусламжаар 17-р, хөнгөлөлттэй зээлээр 36-р, нэг хүнд ноогдох ОДА-ийн хэмжээгээр 1-р байранд явж байна⁹.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ

1. Зүүн хойд Ази судлал сэтгүүл. 1996.№1/7/, х 32 ;
Кокүсай коокэн /Олон улсын нийгэмд оруулах хувь нэмэр/
Кооданшя, 1999 х. 93-94
2. Facts and Figures of Japan 2001. Foreign press center
japan 2001. p. 33-36.
3. North east Asian Study, Series in Japanese. 2001 №1 p.
21-26.
4. Мөн тэнд. х. 27-30.
5. “Вага күни-но сэйфү кайхацү энжэ” /Манай улсын засгийн
газрын хөгжлийн тусламж /Япон улсын Гадаад хэргийн
яамны хэвлэл. 2001.
6. Өнөөдөр сонин. 2000 оны 3-р сарын 20-ны дугаар
7. North east Asian Study, Series in Japan 2001. №1 p. 29.
8. Б.Сэржав. “Монгол-Японы харилцаа: XX зууны сүүлийн
хагаст” диссертаци зохиол. х.87-88
9. “Монгол-Японы харилцаа: эрт, эдүгээ”, УБ, 2002, х.357